

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

2023.06.30

Улаанбаатар хот

№	Арга хэмжээ	Ажил үйлчилгээ	Биелэлт
Нэг. Төрийн албаны шинэтгэл, Хүний нөөцийн бодлого, гүйцэтгэлийн удирдлагын чиглэлээр			
	<p>1.1.Төрийн албаны тухай болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн заалт шаардлагыг ханган ажиллах.</p>	<p>1.1.1.Төрийн албаны Зөвлөлийн тогтоол, шийдвэр, зөвлөмжийг нийт бие бүрэлдэхүүнд хүргэн судлуулж, хэрэгжилтийг хангах арга хэмжээг авах</p>	<p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл нь батлагдсан "Хуралдааны дэг", "Ажил үүргийн хуваарь"-ийг мөрдөж байгаа бөгөөд Байгууллагын цахим хуудсанд байршуулан иргэд, үйлчлүүлэгчдэд мэдээлэн сурталчилж ажиллаж байна.</p> <p>Мөн Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн албан бичиг, зөвлөмжийг харьяа анги нэгжид хүргүүлэн судлуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.</p>
	<p>1.1.2.ШШГБ-ын хүний нөөцийг сонгох, судлах, бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах талаарх хууль, журам, зааврын хэрэгжилтийг хангах удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг эрчимжүүлэх</p>		<p>Алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулахад гол хүчин зүйл болсон цалин, нэмэгдлийг ахиулах бодлогыг барьж Хууль зүй, Дотоод хэргийн сайдын 2023 оны А/22 дугаар тушаалаар Албан тушаалын ангилал, цолны зэрэглэлийг шинэчлэн батлуулсан.</p> <p>Аймгийн төвөөс алслагдсан нутаг дэвсгэрт байрлах шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги, салбар нэгжийн алба хаагчдад тасралтгүй ажилласан 5 жилийн урамшуулал, мөн хүүхэд асрах чөлөөтэй алба хаагчдын цэргийн цолны цалинг 2023.01.01-ний өдрөөс олгож эхлээд байна.</p> <p>Алба хаагчдын амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зорилгоор тэдний амьдралын нөхцөл байдлыг судлан харьяалах нэгжийн саналыг үндэслэн өөрийн орон байргүй 19 алба хаагчид иж бүрэн тавилгатай гэр олгуулах асуудлыг шийдвэрлүүлсэн.</p> <p>Алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарч ажиллах талаар харьяа нэгжүүдийн хүний нөөц хариуцсан ажилтнуудад холбогдох үүрэг чиглэлийг тогтмол өгч ажиллаж байна.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бодлого, хэрэгжилт" сэдэвт суурь судалгааны ажлыг Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвтэй хамтран 2023 оны 02 дугаар сараас 2023 оны 05 дугаар сар хүртэл хугацаанд хийж гүйцэтгэсэн.</p> <p>Судалгааны зорилго нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн өнөөгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийн, тулгамдсан асуудлыг нээн илрүүлэх, улмаар боловсронгуй болгохтой холбоотой дүгнэлт, зөвлөмж боловсруулахад чиглэгдсэн.</p>

		<p>Тус судалгааны ажлын хүрээнд алба хаагчдаас албанаас халшрах хам шинж, сэтгэл ханамжийн түвшин, ажил мэргэжлээс шалтгаалсан өвчлөл, тулгамдаж буй асуудлыг тодорхойлохоор 78 асуулта бүхий асуулгын маягыг бэлтгэн цахимаар хэлбэрээр судалгааг явуулсан.</p> <p>Судалгааны явцад гаргасан дүгнэлтэд үндэслэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох зөвлөмж гаргасан.</p> <p>"Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж удирдлагаас гаргасан алба хаагчийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тушаал, шийдвэр болон холбогдох бусад 13435 хуудас материалыг хувийн хэрэгт баяжилт хийсэн.</p> <p>Анги, алба салбар нэгжийн тэтгэвэрт гарсан 63, чөлөөлөгдсөн 65, халагдсан 6, нас барсан 2, бусад байгууллагын мэдэлд 11, нийт 147 алба хаагчийн хувийн хэрэгт баяжилт хийж Тусгай архивт шилжүүлсэн.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь жөндөрийн эрх тэгш байдлыг хангах ажлыг хууль, журмын хүрээнд зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Өнөөдрийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд нийт алба хаагчдын 35.6 хувийг эмэгтэй алба хаагчид эзэлж байна.</p> <p>Дотоод хэргийн их сургуулийн 2022-2023 оны хичээлийн жилд Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн бакалаврын хөтөлбөрт 68 иргэн, эчнээ ангид 9, магистрт 4, докторт 1, ОХУ-ын ДХЯ-ны харьяа их, дээд сургуулийн бакалаврын хөтөлбөрт 12 эмэгтэй алба хаагчийг байгууллагын захиалгаар тус тус суралцуулж байна.</p> <p>Шалгуур үзүүлэлт хангасан 44 эмэгтэй алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэн томилсон. Удирдах бие бүрэлдэхүүнд 2, ахлах албан тушаалд 11 /ахлах мэргэжилтэн, ахлах шийдвэр гүйцэтгэгч, ахлах нягтлан бодогч, ахлах тогоч гэх мэт/, бусад албан тушаалд 31 байна/.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах тухай 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг харьяа хорих анги, байгууллагад хүргүүлсэн.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын жөндөрийн дэд зөвлөлийн ээлжит хуралдааныг 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулж, хийж хэрэгжүүлсэн ажлаа дүгнэн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтэд анхаарч ажиллах чиглэл өгсөн.</p> <p>Байгууллагын хэмжээнд удирдах албан тушаалтнуудад "Ажлын байрны бэлгийн дарамт", алба хаагчдад "Жөндөрийн эрх тэгш байдал, хүний эрх", "Ажлын байран дахь жөндөрийн эрх тэгш байдал", Жөндөрт суурилсан хүчирхийлэл", "Гэр бүлийн хүчирхийлэл", "Жөндөрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт", "Жөндөрийн мэдрэмжтэй хүний</p>
--	--	--

нөөцийн удирдлагын зарим асуудал, шийдэл", "Хүний эрх, ажлын байрны дарамтын тухай үндсэн ойлголт, хэм хэмжээ", "Хүний эрх ба Жендэрийн тэгш байдал", "Ажлын байрны бэлгийн дарамт", "Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал", "Ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх, үл тэвчих орчинг бүрдүүлэх", "Жендэрийн хэвшмэл ойлголт", "Жендэрийн тухай ойлголт, хүйсийн ялгаатай байдлыг хүндлэх соёлыг төлөвшүүлэх нь", Байгууллагын үйл ажиллагаанд жендэрийн дүн шинжилгээ хийх нь" зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулж, жендэрийн талаарх мэдлэгийн түвшинг нэмэгдүүлээ.

"Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт", "Жендэрийн мэдрэмжтэй хүний нөөцийн удирдлагын зарим асуудал, шийдэл", "Хүний эрх, ажлын байрны дарамтын тухай үндсэн ойлголт, хэм хэмжээ" сэдвээр Удирдлагын академийн Төрийн удирдлагын тэнхимийн багш доктор /Ph.D/ дэд профессор Э.Ариунаа, Ч.Эрдэнэчимэг нар нийт алба хаагчдад сургалт зохион байгуулсан.

Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан сургалч багш бэлтгэх сургалтад 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн Сургалт, хүний нөөц, хэвлэл мэдээлэл, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, дэслэгч Б.Халиун хамрагдаж, Гэрчилгээ авсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь жил бүр "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 өдрийн аян"-нд нэгдэж ирсэн. Тухайлбал, 2021 онд "МАНЛАЙЛАГЧ БАЙЦГААР: ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭСРЭГ ТУУШТАЙ ЗОГСОЖ, ДУУ ХООЛОЙГОО ӨРГӨЕ", 2022 онд "НАНДИН БҮХНЭЭ ХАМГААЛЬЯ-ӨӨРИЙГӨӨ, ГЭР БҮЛЭЭ, ОРЧИН ТОЙРНОО", 2023 онд "НАДААС, ТАНААС, БИДНЭЭС ЭХЛЭЛТЭЙ" уриалгад тус тус нэгдэж, энэ чиглэлээр сургалт зохион байгуулж, богино хэмжээний шторк, мэдээллийг бэлтгэн байгууллагын цахим сайтад байршуулж, олон нийтэд түгээсэн. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанаас "Төрийн цэргийн байгууллагын болон цагдаагийн эмэгтэй алба хаагчдын оролцоог энхийг дэмжих ажиллагаа, аюулгүй байдлын салбар нэмэгдүүлэх боломж" сэдэвт захиалгат төслийн хүрээнд хийгдэж буй "Төрийн цэргийн болон цагдаагийн байгууллагын эмэгтэйчүүд энхийн үйлдсэд" сэдэвт эрдэм шинжилгээний нэгдсэн хуралд "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эмэгтэй алба хаагчид энхийн үйлсэд" сэдвээр илтгэл тавьсан. Ингэснээр энхийг дэмжих ажиллагаанд тус байгууллагын эмэгтэй алба хаагчдын оролцоог нэмэгдүүлэх боломжийг нээж өгсөн.

Тухайлбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь эмэгтэй алба хаагч олонтой, төрөл мэргэжил бүрт эмэгтэй алба хаагчид үүрэг гүйцэтгэх боломжтой, судалгаанд оролцсон эмэгтэй алба хаагчдын 71.9 хувь нь энхийг дэмжих ажиллагаанд оролцох хүсэлтэй байсан ба

		<p>жилд дунджаар эмнэлгийн мэргэжлийн ажигтнаар 2, нийгмийн ажигтан, сэтгэл зүйчээр 2, холбоочин мэргэжлээр 1, бусад төрлийн мэргэжлээр 5 /эрх зүй, санхүүгийн ажигтан, тоо бүртгэл, хүний нөөц/ эмэгтэй алба хаагч оролцох боломж бүрдэж байгаа юм.</p> <p>"Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тохиолдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын "Эмэгтэйчүүдийн зөвлөл" Хилпийн чанад дахь Монголчуудын зөвлөлтэй "Хамтран ажиллах санамж бичиг" байгууллаа. Санамж бичгийн хүрээнд тус байгууллагын эмэгтэй алба хаагчдын нийгмийн харилцаанд дахь манлайлал, оролцоот нэмэгдүүлэх, өөрийгөө хөгжүүлэх боломжийг олгохын зэрэгцээ боловсролын чиглэлээр төсөл хөтөлбөр хамтран хэрэгжүүлж, харилцан мэдээлэл солилцохоор шийдвэрлэсэн.</p> <p>Санамж бичгийн хүрээнд англи хэлний зохих мэдлэгтэй, БНХАУ-ын их дээд сургуульд тэтгэлэгээр суралцах хууддуудийн судалгааг авч, сонгон шалгаруулах ажлыг зохион байгууллаа.</p> <p>Монголын залуучуудын холбооны дэргэдэх Эмэгтэйчүүдийн холбооноос зохион байгуулсан Анхдугаар чуулганд 10 эмэгтэй алба хаагч оролцсон.</p>
	<p>1.1.4."Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын дагуу нийт албан хаагчдын хувийн хэрэгт баяжилт хийх ажлын явц байдалд хяналт тавин, хэрэгжилтийг хангуулах.</p>	<p>"Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажилгаж удирдлагаас гаргасан алба хаагчийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тушаал, шийдвэр болон холбогдох бусад 13435 хуудас материалыг хувийн хэрэгт баяжилт хийсэн.</p> <p>Анги, алба салбар нэгжийн тэтгэвэрт гарсан 63, чөлөөлөгдсөн 65, халагдсан 6, нас барсан 2, бусад байгууллагын мэдэлд 11, нийт 147 алба хаагчийн хувийн хэрэгт баяжилт хийж Тусгай архивт шилжүүлсэн.</p>
	<p>1.1.5.Төрийн албаны шатлан дэвших нөөцөд хамрагдах төрийн албан хаагчдын судалгааг гаргаж, шатлан дэвшүүлэх болзол, шаардлагыг хангасан алба хаагчдыг томилох бодлого, зарчмын хэрэгжилтийг хангуулж ажиллах</p>	<p>Удирдах болон гүйцэтгэх албан тушаалд дэвшин томилогдох боломжтой шаардлага хангасан алба хаагчдын судалгааг гаргасан.</p> <p>Тайлангийн хугацаанд 178 алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэн томилсон.</p>
	<p>1.1.6.Алба хаагчдын шилжилт хөдөлгөөн, шатнаж урамшуулах, хариуцлага тооцох ажлыг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулж буйд хяналт тавин, холбогдох албан тушаалтанд танилцуулан шийдвэрлүүлэх</p>	<p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа байгууллагуудын сул орон тоонд иргэнийг судлан зохиох албан тушаалд томилох 274, албан тушаалд дэвшүүлэх 178, шилжүүлэх 204, өөрийн хүсэлтээр чөлөөлөх 127, бусад байгууллагын мэдэлд шилжүүлэх 22, цагинтай болон цагингүй чөлөө олгох 19, хүүхэд асрах чөлөө 51, тусламж олгох 45 асуудлыг судалж, танилцуулан шийдвэрлүүлсэн.</p> <p>Нэгжийн даргын тушаалаар 95 алба хаагчийг шилжүүлж, 137 иргэнийг шинээр томилж, 139 алба хаагчийг чөлөөлж, 20 алба хаагчид</p>

		<p>хүүхэд асрах чөлөө, 95 алба хаагчид тусламж олгосон байна.</p> <p>Шагнал урамшууллын талаар:</p> <p>"Цэргийн гавьяаны улсан тугийн одон"-оор 5, "Цэргийн гавьяаны одон"-оор 8, "Цэргийн хүндэт медаль"-аар 118 буюу 128 алба хаагч, 3 ахмад ажилтан, нийт 131 хүн төрийн дээд шагналаар шагнагдсан.</p> <p>"Хууль зүйн албаны тэргүүний ажилтан хүндэт" тэмдгээр 6, "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан" хүндэт тэмдгээр 28, "Хүндэт жуух бичиг"-ээр 78 алба хаагч буюу Хууль зүй, дотоод хэргийн яамны шагналаар нийт 112 алба хаагч шагнагдсан.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шагналаар Төрийн хуяг шагналаар 3, Хүндэт ажилтан тэмдгээр 13, Жүүх бичгээр 3, Албаны төлөө I медалиар 20, Салбарын тэргүүний ажилтан тэмдгээр 34, Албаны төлөө II медалиар 28, Тэргүүний шийдвэр гүйцэтгэгч 3, Хүндэт тэмдгээр 55, Албаны төлөө III медаль 46, Баярын бичиг 47, Мөнгөн шагналаар 69, сарын үндсэн цалингийн хувиар 102, мөнгөн урамшуулал 14 буюу 391 алба хаагч, 46 ахмад ажилтан, нийт 437 хүнийг давхардсан тоогоор тус тус шагнаж урамшуулсан байна.</p> <p>"Цэргийн цол олгох журам"-ын дагуу тэмдэглэлт баярыг тохиолдуулан Зэвсэгт хүчний жанжин штабын даргын тушаалаар 3, харьяа газар, хэлтэс, албадудаас ирүүлсэн санал, тодорхойлолтыг үндэслэн ШШГЕГ-ын даргын тушаалаар 388 алба хаагчид цэргийн цол олгож, 52 алба хаагчийн урьд хэрэглэж байсан цолыг сэргээсэн.</p> <p>Нэгжийн даргын тушаалаар 46 алба хаагчид цэргийн цол олгож, 28 алба хаагчийн цолыг сэргээсэн байна.</p> <p>Тайлангийн хугацаанд 80 алба хаагчийг цэргийн алба хаасны, хувь тэнцүүлсэн болон өндөр насны тэтгэвэр тогтоологдох асуудлыг шийдвэрлүүлсэн.</p> <p>ШШГЕГ-ын даргын тушаалаар эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандсан 10 алба хаагчийг албанаас халж, 79 алба хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан. /албан тушаал бууруулах 18, цол бууруулах 4, цолны мөнгө хасах 4, албан тушаалын цалинг бууруулах 18, сануулах 35/</p> <p>Нэгжийн даргын тушаалаар 301 алба хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан байна. /цол бууруулах 7, цолны мөнгө хасах 72, албан тушаалын цалин бууруулах 100, сануулах 122/</p>
--	--	--

Хоёр. Төрийн албаны хүний нөөцийн мэдлэг боловсрол, хөгжлийн бодлогын төлөвлөлт, хэрэгжилт

2	<p>2.1. Алба хаагчдын мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг хөгжүүлэх</p>	<p>2.1.1. Гадаад, дотоодын их дээд сургууль, удирдлагын академийн бакалавр, магистр, удирдлага, докторын сургалтад алба хаагчдыг хамруулан, чадавхыг бэхжүүлэх.</p>	<p>2.1.2. Байгууллагын хэмжээнд "2022-2023 онд зохион байгуулах алба хаагчдыг чадавхжуулах сургалтын хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангах.</p>	<p>ДХИС-ийн Удирдлагын академийн докторын хөтөлбөрт 4, магистрын хөтөлбөрт 7 алба хаагч; ДХИС-ийн ШШГАС-ийн докторын хөтөлбөрт 5, магистрын хөтөлбөрт 11, бакалаврын 3 жилийн эчнээ хөтөлбөрт 63, бакалаврын 5 жилийн эчнээ хөтөлбөрт 23 алба хаагч; ОХУ-ын ДЯ-ны харьяа их, дээд сургуулийн адъюнктурт 1, удирдлагын академийн магистрын хөтөлбөрт 3, бакалаврын хөтөлбөрт 18 алба хаагч тус тус суралцуулж байна. ХЗДХС-ын 2023.05.29-ний өдрийн А/187 дугаар тушаалаар байгууллагын захиалгаар ОХУ-ын ДЯ-ны харьяа их, дээд сургуулийн 2023-2024 оны хичээлийн жилд бакалаврын хөтөлбөрт 6, магистрын хөтөлбөрт 3 алба хаагчийг суралцуулахаар шийдвэрлэсэн. ДХИС-ийн Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн "Харуул хамгаалалтын албаны ажилтан" бэлтгэх чадамжид суурилсан 90 хоногийн сургалтад 165 иргэнийг танхимын хэлбэрээр суралцуулан төгсгөсөн. Мөн Шийдвэр гүйцэтгэчийн нөөц бүрдүүлэх зорилгоор "Шийдвэр гүйцэтгэчийн сонгон шалгаруулалт"-ыг 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр явуулж, сорилын болон ярилцлагын шалгалтад тэнцсэн 33 оролцогчийг Орон тооны бус мэргэжлийн комиссоос шалгалтын дүнг баталгаажуулж, шийдвэр гүйцэтгэчийн нөөцөд бүртгэсэн. Байгууллагын сул орон тоог нөхөх зорилгоор ОХУ-ын ДХЯ-ны харьяа их, дээд сургууль, ДХИС-ийн ШШГА-ны сургууль, Ахлагчийн сургууль төгсөгчид болон шийдвэр гүйцэтгэчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэд, ажиллаж байгаа алба хаагчдаас нөөц бүрдүүлэлтийг зохион байгуулан ажиллаж байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар ШШГЕГ-ын даргын тушаалаар 274 иргэнийг шинээр, 178 алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэн, 204 алба хаагчийг шилжүүлэн томилсон. Нэгжийн даргын тушаалаар 95 алба хаагчийг шилжүүлж, 137 иргэнийг шинээр томилсон байна.</p>	<p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Даргын 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/215 дугаар тушаалаар "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад 2022-2023 онд зохион байгуулах сургалтын хөтөлбөр"-ийг батлуулан, нийт анги, байгууллагуудад хүргүүлж, сар бүр сургалтын тайлан мэдээг авч нэгтгэн, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж байна. Харьяа анги байгууллага, салбар нэгжүүд сургалтын хөтөлбөрийн дагуу өөрсдийн анги нэгжийн алба хаагчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн сургалтын төлөвлөгөө боловсруулж, нэгжийн даргын тушаалаар батлуулан, сургалтыг дараах чиглэлийн хүрээнд зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:</p>
---	---	---	---	---	---

		<p>- Алба хаагчийн бие бялдрын бэлтгэлжилт, норматив хангах сургалт;</p> <p>- Цэргийн албаны нийтлэг дүрэм, цэргийн хэргийн мэдлэг олгох сургалт;</p> <p>- Үндэсний Монгол бичгийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт;</p> <p>- Гадаад хэл мэдлэгийн түлхүүр сургалт;</p> <p>- "Зангиа академи"-ийн цахим сургалт;</p> <p>2023 оны эхний хагас жилийн байдлаар удирдах ажилтнууд, хорих анги, байгууллагын харуул хамгаалалт, гүйцэтгэх ажил эрхэлсэн дэд дарга, цагдан хорих байрны дарга, төлөөлөгч, ахлах төлөөлөгч, ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч, архив, бичиг хэргийн ажилтан, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажилтнууд, хүний тоо бүртгэлийн байцаагч, туслах, холбоо мэдээллийн технологийн инженерүүд, эмч, эмнэлгийн ажилтнууд зэрэг 10 төрөл мэргэжлийн 696 алба хаагч танхимын болон цахим сургалтад хамрагдсан.</p> <p>- Хөмрөг үүсгэгч байгууллагуудын архив, бичиг хэргийн ажилтан болон бичиг хэргийн ажил хариуцсан алба хаагчдад Архивын ерөнхий газрын Мэргэжил, арга зүйн удирдлагын газрын архивын баримтын тоо бүртгэл, статистик мэдээ хариуцсан мэргэжилтэн Л.Өнөртүяа сургалт зохион байгуулсан.</p> <p>Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвтэй хамтран "Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх" сургалтад хотын бүсийн хорих анги, байгууллагуудын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажилтнууд болон аюулгүй байдал хариуцсан алба хаагчид хамрагдсан.</p> <p>ШШГЕГ-ын алба хаагчдад Удирдлагын академийн багш нараар Манлайлаг, Хүний эрх ба жөндөр, Албан бичиг боловсруулалт сэдвүүдээр нийт 15 цагийн сургалт зохион байгуулсан.</p> <p>Мөн Чингэлтэй дүүргийн онцгой байдлын хэлтэс, Гал унтраах 10 дугаар ангитай хамтран Гал унтраах, гамшгаас урьдчилан сэргийлэх тухай 2 цагийн танхимын сургалт зохион байгуулсан.</p> <p>Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх асуудлаар байгууллагын хэмжээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.</p> <p>Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж багтах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журамд заасан хугацаанд албан хаагчийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэж, баталгаажуулан ажиллаж байна.</p>
<p>2.1.3.Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх асуудлаар байгууллагын хэмжээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, удирдлагаар хангах;</p>		

	<p>2.1.4."Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжилтийг ханган ажиллах;</p>	<p>Зүүн бүсийн албадан эмчилгээний төв байгуулах болсонтой холбогдуулан нэн шаардлагатай 18 орон тоог харьяа алба, хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн орон тооноос шилжүүлэн авч, "Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Зүүн бүсийн албадан эмчилгээний төвийн үйл ажиллагааг эхлүүлсэн. Хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн ажлын онцлог, ачааллыг харгалзан тус нэгжийн саналыг үндэслэн орон тоог нэгж хооронд эсвэл тухайн нэгж дотор шаардлагатай орон тоонд шилжүүлж өөрчлөх асуудлыг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна.</p> <p>2023 оны эхний хагас жилийн байдлаар ШШГЕГ-ын даргын тушаалаар 38 алба хаагч, нэгжийн даргын тушаалаар 300 алба хаагчийн цалин, нэмэгдлийг ахиулсан.</p>
<p>3</p> <p>2.2.Төрийн албан хаагчийн ёс зүйн талаар төрийн албан хаагчдын соён гэгээрүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, гаргасан зөрчлийг таслан зогсоох, цаг тухайд нь шийдвэрлэх, холбогдох албан хаагчдад хариуцлага хүлээлгэх,</p>	<p>2.2.1."Төрийн албаны сахилга, дэг журмыг чангатгах тухай" Монгол Улсын Засгийн газрын тогтоол, албан даалгаврын хэрэгжилтийн байдлыг шалган танилцаж, холбогдох үүрэг, чиглэл өгч биелэлтэд хяналт тавих</p>	<p>ШШГЕГ-ын харьяа хорих анги, байгууллагын Сахилга, ёс зүйн салбар хороод нь Монгол Улсын Засгийн газрын 2017 оны "Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 01 дүгээр албан даалгавар, 2018 оны "Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 258 дугаар тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/105 дугаар тушаалаар батлагдсан "Салбарын албан хаагчдын ёс зүйн үлгэрчилсэн заавар" Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн А/183 дугаар тушаалаар батлагдсан "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм", зэргийг алба хаагчдад танилцуулах, бие даан судлуулах, үйл ажиллагаандаа дагаж мөрдөх, хэрэгжүүлэх чиглэлийн дагуу сургалтуудыг зохион байгуулж, сахилга, ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилласан.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Сахилга, ёс зүйн хороо нь "Төрийн албаны тухай хууль", "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм", "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйлчилгээний стандарт", цэргийн албаны нийтлэг дүрэм болон бусад хууль тогтоомж, журам, зааврыг өдөр тутамдаа мөрдлөг болгон ажиллаа.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/125 тоот тушаалаар "Сахилга, ёс зүйн хороо"-г шинэчлэн байгуулсан.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд хагас жилийн байдлаар ШШГЕГ-ын даргын тушаалаар нийт 89 алба хаагч арга хэмжээ авалгсан. Үнд: Албанаас халах 10, албан тушаал бууруулах 18, цэргийн цол бууруулах 4, үндсэн цалин бууруулах 18, ганцаарчилж сануулах 13, нийтийн өмнө сануулах 22.</p>

		<p>Анги, байгууллагын даргын тушаалаар нийт 309 алба хаагч арга хэмжээ авалдсан. Үүнд: Албанаас халах 8, цэргийн цол бууруулах 7, үндсэн цалин бууруулах 100, цолны мөнгө хасах 72, ганцаарчилж сануулах 31, нийтийн өмнө сануулах 91.</p> <p>ШШГБ-н хэмжээнд нийт 398 алба хаагч сахилга, ёс зүйн зөрчил гарган арга хэмжээ тооцогдсон байна.</p> <p>2023 оны эхний хагас жилийн байдлаар сахилга, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол 22 ирснийг шалган шийдвэрлэсэн байна. Хорих анги, байгууллагын Сахилга, ёс зүйн салбар хороод нь давхардсан тоогоор нийт 476 алба хаагчийн "Сахилгын талон"-д тэмдэглэгээ хийж анхааруулан ажиллажээ.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, газар, хэлтэс, хорих анги, салбар, нэгжүүдийн Сахилга, ёс зүйн салбар хороод нь доорх ажил арга хэмжээг нийтлэг байдлаар хэрэгжүүлж ажиллажээ. Үүнд:</p> <p>Сахилга, ёс зүйн салбар хороог шинэчлэн байгуулж, хийх ажлын төлөвлөгөөг жил, улирлаар гарган батлуулсан.</p> <p>Сахилга ёс зүйн хорооны хурлыг сар бүр, улиралд, тухай бүр гэсэн зарчмаар хурлыг хийж, сахилга, ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчдын сахилга, ёс зүйн салбар хорооны хурлаар хэлэлцэн дүгнэлт гаргаж, даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж ажиллажээ.</p> <p>Алба хаагчдын гаргасан зөрчилд нь дүн шинжилгээ хийж, үр дүнгийн талаар нийт бие бүрэлдэхүүнд танилцуулж ажилласан байна.</p> <p>Анги байгууллагууд Сахилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр дотоодын хяналт, шалгалт болон Ёс журмын эргүүлийг тогтмол ажиллуулсны хүрээнд тодорхой хэмжээний сахилга, ёс зүйн зөрчлийг газар дээр нь таслан зогсоож ажилласнаараа шинэлэг ажил болсон.</p> <p>Алба хаагчдыг Соён гэгээрүүлэх, сахилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, хууль эрх зүйн мэдлэг, харилцаа хандлагыг дээшлүүлэх, хамт олны уур амьсгалыг зэрэгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, ажлын байран дахь стресс, бухимдлыг даван туулах, өөрийгөө хөгжүүлэх, удирдах, манлайлах чадварыг дээшлүүлэх, бие бялдраа хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх чиглэлийн мэдлэг олгох сургалтуудыг өөрийн албан хаагч нар болон бусад газраас мэргэжлийн багш,</p>
<p>2.2.2. Алба хаагчдын гаргасан сахилга, ёс зүйн зөрчилд дүгнэлт хийж, судлан харьяа нэгжүүдэд зөвлөмж хүргүүлэх;</p>		

		<p>судлаач, төрийн албан хаагчдыг урьж оролцуулан зохион байгуулан ажиллажээ.</p> <p>Сахилга, ёс зүйн зөвлөгөөнийг улирал бүр зохион байгуулж, хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнан, хамт олны санал бодлыг сонсож, цаашид хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгаж, үр дүн гарган ажилласан алба хаагчдыг шатнан урамшуулж, сахилга, ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч нарт хариуцлага тооцон ажилласан нь үр дүнд хүрч байна.</p>
	<p>2.2.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон төрийн алба хаагч хооронд гарсан маргааныг хүлээн авч, шийдвэрлэх;</p>	<p>Тайлангийн хугацаанд Салбар зөвлөлд ирүүлсэн өргөдөл гомдол байхгүй болно.</p>
<p>4</p> <p>2.3. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах ажлыг зохион байгуулах, үр дүнг тооцох</p>	<p>2.3.1. Сул орон тооны захиалгад тулгуурлан төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх тухай зарлагыг ШШГЕГ-ын цахим хуудаст байршуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж, нээлттэй ил тод байдлыг хангах;</p> <p>2.3.2. Төрийн албаны зөвлөлөөс дэвшүүлсэн төрийн албан хаагчийн сургалт, хөгжилтэй холбоотой асуудлыг Төрийн албаны тухай хууль тогтоомжид заасан агуулга, хэлбэрээр нь шинэчлэн зохион байгуулах, хамтрагч байгууллагуудын хооронд зохистой хамтын ажиллагааны горимыг тогтоох зорилтын хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн сул орон тоог нөхөх, ахлагч бүрэлдэхүүний нөөц бүрдүүлэх зорилгоор холбогдох арга хэмжээг зохион байгуулсан байдалд хяналт тавин, үр дүнг</p>	<p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн сул орон тоог нөхөх, нөөц бүрдүүлэх зорилгоор сонгон шалгаруулалтын зарыг мэдээлж, ажилд орох хүсэлт гаргасан иргэдийг бүртгэж, журамд заасан болзол шаардлага, тухайн албан тушаалд тавигдах ерөнхий ба тусгай шаардлагад нийцүүлэн сонгон шалгаруулалтыг явуулж, ДХИС-ийн Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн "Харуул хамгаалалтын албаны ажилтан" бэлтгэх сургалт, "Офицер" бэлтгэх дамжаанд хамруулж, тэнцсэн иргэдийг албан тушаалд томилон ажиллаж байна.</p> <p>2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургуулиас зохион байгуулсан "Ажил олгогчидтой хийх нэгдсэн уулзалт"-д 401 дүгээр хаалгатай хорих анги-Нэгдсэн эмнэлэг оролцож, Сувилахуйн сургуулийн төгсөх дамжааны оюутнуудтай уулзан тус байгууллагад ажиллахын давуу талыг сурталчилсан.</p> <p>Нэн шаардлагатай албан тушаалын сул орон тооны мэдээллийг болон ажилд орох хүсэлтэй иргэдэд тавигдах шаардлага, бүрдүүлэх</p>

	<p>тооцон дүгнэх:</p>	<p>материалын жагсаалт зэргийг байгууллагын цахим хаягт тогтмол байршуулж байна.</p> <p>Ерөнхий боловсролын төгсөх ангийн хүүхдүүдэд эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Бидний бахархал" арга хэмжээг Хан-Уул дүүргийн 32, 75 дугаар дунд сургуулиудад зохион байгуулсан.</p> <p>Байгууллагын сул орон тоог нөхөх зорилгоор өмнөх оны нөөцөд бүртгэлтэй ДХИС-ийн ШШГ-А-ны сургуулийн 3 сонсогч, Ахлагчийн сургуулийг төгссөн 75, шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн 45 иргэнээс нөөц бүрдүүлэлтийг зохион байгуулан ажиллаж байна</p>
	<p>2.3.3. Төрийн тусгай албан тушаалд анх орох болон ДХИС-ийн Ахлагчийн сургуульд элсэн суралцах хүсэлтэй иргэн, шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад орох хүсэлтэй иргэдээс авах мэргэшлийн шалгалтыг Дотоод хэргийн их сургууль зэрэг холбогдох нэгжтэй хамтран зохион байгуулах;</p>	<p>ДХИС-ийн Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн "Харуул хамгаалалтын албаны ажилтан" бэлтгэх чадамжид суурилсан 90 хоногийн сургалтад 165 иргэнийг танхимын хэлбэрээр суралцуулан төгссөн.</p> <p>Мөн Шийдвэр гүйцэтгэгчийн нөөц бүрдүүлэх зорилгоор "Шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт"-ыг 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр явуулж, сорилын болон ярилцлагын шалгалтад тэнцсэн 33 оролцогчийг Орон тооны бус мэргэжлийн комиссоос шалгалтын дүнг баталгаажуулж, шийдвэр гүйцэтгэгчийн нөөцөд бүртгэсэн.</p> <p>Байгууллагын сул орон тоог нөхөх зорилгоор ОХУ-ын ДХЯ-ны харьяа их, дээд сургууль, ДХИС-ийн ШШГ-А-ны сургууль, Ахлагчийн сургууль төгсөгчид болон шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэд, ажиллаж байгаа алба хаагчдаас нөөц бүрдүүлэлтийг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>2023 оны эхний хагас жилийн байдлаар ШШГЕГ-ын даргын тушаалаар 274 иргэнийг шинээр, 178 алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэн, 204 алба хаагчийг шилжүүлэн томилсон.</p> <p>Нэгжийн даргын тушаалаар 95 алба хаагчийг шилжүүлж, 137 иргэнийг шинээр томилсон байна.</p>
	<p>2.3.4. Төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх, нөхөн хангалтыг хийх;</p>	<p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн сул орон тоог нөхөх, нөөц бүрдүүлэх зорилгоор сонгон шалгаруулалтын зарыг мэдээлж, ажилд орох хүсэлт гаргасан иргэдийг бүртгэж, журамд заасан болзол шаардлага, тухайн албан тушаалд тавигдах ерөнхий ба тусгай шаардлагад нийцүүлэн сонгон шалгаруулалтыг явуулж, ДХИС-ийн Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн "Харуул хамгаалалтын албаны ажилтан" бэлтгэх сургалт, "Офицер" бэлтгэх дамжаанд хамруулж, тэнцсэн иргэдийг албан тушаалд томилон ажиллаж байна.</p>
	<p>2.3.5. Төрийн албаны үйлчилгээний чанар хүртээмж, үр нөлөө, алба хаагчдын зан харьцааны талаар санал хүсэлтийг</p>	<p>-Иргэд, байгууллагад архивын үйлчилгээ үзүүлж, ШШГЕГ-ын цахим хуудсаар дамжуулан онлайн захилта 51, захиалгын хуудсаар 261, нийт 312 иргэн, алба хаагчаас архивын захиалга хүлээн авч, 297 хүсэлтийг</p>

	авч дүгнэх;	<p>ШИЙДВЭРЛЭСЭН. Үүнээс лавлагаа-253, цаалингийн тодорхойлолт-8, архивын тодорхойлолт-3, 67 иргэн, алба хаагчдад 604 хуудас баримтын хуулбар тус тус олгосон.</p> <p>Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад архивын захиалга 29.1 хувиар, архивын үйлчилгээ үзүүлсэн байдал 39 хувиар тус тус өссөн үзүүлэлтэй байна.</p> <p>Мөн 30 иргэний хүсэлтийн дагуу хувийн хэрэгт хадгалагдаж байсан 36 эх баримтыг олгож, 21 иргэний хөдөлмөрийн дэвтэр болон нийгмийн даатгалын дэвтэрт 100 тушаалын бичилт хийсэн.</p> <p>Тайлант хугацаанд гадны байгууллагаас 3 алба хаагч, хөмрөг үүсгэгч байгууллагаас 5 алба хаагч, нийт 8 алба хаагч, иргэн уншлагын танхимаар үйлчлүүлж, 93374 хуудас 1301 баримт олгосон байна.</p> <p>-Шинэчлэн батлагдаж, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд тус хуулийн 8 дугаар зүйлд 68 төрлийн мэдээллийг ил тод, нээлттэй болгохоор заасан ба мэдээллийг ил тод болгосон эсэхийг тодорхойлох 98 шалгуур үзүүлэлтийн дагуу холбогдох мэдээллүүдийг sd.gov.mn цахим хуудаст байршуулж, хэрэгжилтийг Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн бөгөөд тус яамны https://shien.gov.mn/ сайтад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 98.70 хувиар үнэлэгдэж, агентлагуудаас долдугаар байрт жагсаж байна.</p> <p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд харьяа анги, байгууллага, салбар нэгжүүдэд нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах тухай үүрэг чиглэлийг 05/1266 дугаар албан бичгээр хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Иргэд, олон нийтийн санаа бодолд дүн шинжилгээ хийх, удирдлагыг мэдээллээр хангах, хүрээнд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд нийтлэгдсэн байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчтай холбоотой зөрөг, сөрөг болон нийгэмд өрнөж буй цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийн тоймыг 110 удаа бэлтгэн танилцуулсан.</p>
Гурав. Төрийн захиргааны хөгжлийн бодлого, удирдлага, мэдээллийн тогтолцоо		
<p>5</p> <p>3.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээний төрийн албан хаагчтай холбоотой мэдээ, тайлан, судалгааг Төрийн албаны зөвлөлөөс баталсан загвар, графикийн дагуу гаргаж, хүргүүлэх</p>	<p>3.1.1.Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн мэдээллийг гаргах талаар харьяа нэгжийн хүний нөөцийн ажиглалтад арга зүйн зөвлөгөө өгөх, тайланг авч нэгтгэх;</p> <p>3.1.2.Салбар зөвлөлгийн тайлан, мэдээг тогтоосон хугацаанд хүргүүлэх;</p>	<p>Харьяа алба, хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, салбар нэгжийн хүний нөөцийн ажиглалтад тогтмол мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилладаг.</p> <p>Нэгжийн даргын тушаалаар хийгдсэн шилжилт хөдөлгөөний мэдээг авч 7 хоног бүр авч, нэгтгэн ажиллаж байна.</p> <p>Салбар зөвлөлгийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, мэдээ судалгааг гарган, 2023.01.10-ны өдрийн 01/69 дүгээр албан бичгээр төрийн албаны төв байгууллагад хүргүүлсэн.</p>

	<p>3.2. Салбар зөвлөлийн үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтэд ил тод, нээлттэй хүргэн сурталчлах, холбогдох мэдээллийг түүнд байршуулах ажлыг зохион байгуулах</p>	<p>Салбар зөвлөлийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төрийн албаны зөвлөлийн "7.4:10" арга зүйн 16 удаагийн сургалтад харьяа алба, хорих анги, газар, салбар нэгжийн алба хаагчдыг тогтмол хамруулан ажиллаж хэвшсэн. Тайлангийн хугацаанд Салбар зөвлөлд ирүүлсэн өргөдөл гомдол байхгүй болно. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын сул орон тооны мэдээллийг 7 хоног тутам гаргаж удирдах албан тушаалтнуудад танилцуулахын зэрэгцээ нэн шаардлагатай албан тушаалын сул орон тооны мэдээллийг байгууллагын сайтад байршуулдаг. Салбар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, мэдээ судалгааг гарган, 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн ШШГЕГ-ын даргын 01/69 дүгээр албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний Биелэлтийг ШШГЕГ-ын веб хуудаст байршуулсан.</p>
Дөрөв. Салбар зөвлөлийн дотоод ажлын зохион байгуулалт		
<p>6 4.1. Салбар зөвлөлийн дотоод ажлын зохион байгуулалт, хэвийн ажиллагааг хангах</p>	<p>4.1.1. Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын хөтөлбөрийг урьдчилан гаргаж, холбогдох материалыг гишүүдэд тараан өгч танилцуулан хуралдааны бэлтгэлийг хангах, хуралдааны тэмдэглэлийг албажуулж, гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавин дүгнэх. 4.1.2. Салбар зөвлөлийн урьд оны баримтуудыг стандартын дагуу цэгцлэх, үдэж хавтаслан Тусгай архивт шилжүүлэх</p>	<p>Салбар зөвлөл нь хууль, журамд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 7 удаа хуралдаж шаардлагатай цаг үеийн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэж ажилласан. Хуралдааны хөтөлбөрийг урьдчилан гаргаж батлуулан, хуралдааны тэмдэглэлийг албажуулан ажиллаж байна. Салбар зөвлөлийн 2022 оны баримтуудыг стандартын дагуу цэгцлэн, үдэж хавтаслан Тусгай архивт шилжүүлсэн болно.</p>

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ**